



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2020.11.24 № 516

таний _____ -ны № _____ -т

**АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ДАРГА Д.АЛТАНГЭРЭЛ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрх, Сонгуулийн тухай хуулийн 10.5-д заасны дагуу "Орон нутгийн ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл"-д аудит хийж аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт: 15 хуудастай

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР



C:\Users\Public\2019 share\Ujig-tsogi.doc



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

АУДИТЫН КОД: : АРА-2020/05-ГА

Цэцэрлэг хот
2020 он

**Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр**

Утас: 7033-3141 Цахим хаяг: Ulambayard@audit.gov.mn

Аудитын менежер Т.Байгалмаа

Утас: 7033-2860 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

ГАБ-ийн ахлагч, Ахлах аудитор Д.Нэргүйбаатар

Утас: 7033-3019 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

САБ-ийн аудитор В.Цогжаргал

Утас: 7033-3019 Цахим хаяг: Tsogjargal.b@audit.gov.mn

САБ-ийн аудитор Х.Алтанчимэг

Утас: 7033-3019 Цахим хаяг: Altanchimeg.kh@audit.gov.mn

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
Тайлан бэлтгэсэн:	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	4-5
Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.	6-8
Тэргүүлэх аудитор: Д. Уламбаяр		6-6
Аудитын менежер: Т.Байгалмаа	1.1. Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.	6-8
Ахлах аудитор: Д.Нэргүйбаатар		
Аудитор: В. Цогжаргал	БҮЛЭГ 2. АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.	8-13
Аудитор: Х.Алтанчимэг	2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.	8-11
2020 оны 11 дүгээр сар	2.2. Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг бодитоор тайлагнаж аудитаас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.	11-12
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn	2.3. Хөрөнгийн зарцуулалтанд тавих дотоод хяналт үр дүнтэй байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу	ДҮГНЭЛТ ХАВСРАЛТУУД	
ХАЯГ: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 311 тоот		



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ЗДТГ	Засаг Даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МТБ	Мэдээлэл, технологийн баг
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
СХ	Сонгуулийн хороо
УИХ	Улсын Их Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит

Хүснэгт болон графикийн тайлбар

Хүснэгт-1	Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн хуваарилалт
Хүснэгт-2	Сумдад хуваариласан санхүүжилт
Хүснэгт-3	Нийт зардлын гүйцэтгэлийн тайлан
Хүснэгт-4	Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийн тайлан
Хүснэгт-5	Нэмэлт сонгуулийн зардлын зарцуулалт
Хүснэгт-6	Шатахууны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт-7	Зардлын гүйцэтгэлийн тулгалт
График-1	Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн хуваарилалтын график



АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

АУДИТ ҮНДЭСЛЭЛ, ЭРХ:

ХИЙХ БҮРЭН

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/53 дугаар тушаал, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.23 дахь хэрэгжүүлэх арга хэмжээг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Аймаг, сум ИТХ-ийн 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах, улмаар зөвлөмж боловсруулан аймгийн Сонгуулийн хороо, холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Аймаг, сумын ИТХ-ын зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ:

Аудитад аймаг болон 19 сумын сонгуулийн хороодыг хамрууллаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS6817-4:2020, Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт боловсрууллаа.

АУДИТАД АШИГЛАСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хуулийн эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;
- Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлан, 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна.

Аймаг, сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг аймгийн 25 тойрогт 39 мандаттай, сумын 101 баг, хороонд 433 мандаттайгаар зохион байгуулсан. Үүнтэй холбоотойгоор аймгийн сонгуулийн хороонд 2, сумдын сонгуулийн хороонд 97, хэсгийн хороодод 807 гишүүн тус тус ажилласан бол мэдээллийн технологийн чиглэлээр 130, хамгаалалтанд цагдаагийн 105 албан хаагч, улсын бүртгэлийн 105 итгэмжлэгдсэн ажилтан, эрүүл мэндийн болон үйлчилгээнд 252 нийт 1507 ажилтан, албан хаагч ажилласан байна.

Аймаг, сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг 534,835.0 мянган төгрөгөөр төсөвлөж, гүйцэтгэлээр 526,173.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 8,661.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

**АУДИТ ХИЙХ
ХУГАЦАА, БАГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2020 оны 10 сарын 28-ны өдрөөс эхлүүлж, талбарын ажлыг 2020 оны 11 сарын 03-аас гүйцэтгэн аудитын дүгнэлтийг 2020 оны 11 сарын 20-ны дотор аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэхээр төлөвлөн, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нэргүйбаатар, аудитор В.Цогжаргал, Х.Алтанчимэг нар гүйцэтгэлээ.

**ХҮНДРЭЛ,
БЭРХШЭЭЛ:**

Аудитыг гүйцэтгэх явцад улс орныг хамарсан цар тахлын улмаас хөл хорио тогтоож аудиторууд цахимаар ажилласан болон сумдад хуваарилсан шатахууны зарцуулалтыг хэсгийн хороод тус бүрээр гаргаагүйгээс зарим сумын шатахууны зарцуулалтын тайланг зардлын ангиллаар тулган шалгахад хүндрэлтэй байлаа.



БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМДЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

Аймаг сумдын ИТХ-ын 2020 оны сонгууль зохион байгуулахад батлагдсан төсвийг Архангай аймгийн сонгуулийн хороо хууль журмын дагуу хэсгийн хороодод хуваарилж, зарцуулжээ.

1.1. Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Улсын төсвөөс аймгийн Сонгуулийн хороонд сонгууль зохион байгуулахтай холбогдуулан нийт **534,835.0** мянган төгрөгийн санхүүжилтийг олгосныг дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт №1 /мян.төг/


№	Зардлын нэр	Улсын төсвөөс хуваарилсан	Нийт зардалд эзлэх хувь	Аймгийн СХ-оос хуваарилсан	
				Сумын СХ- нд олгосон	Аймгийн СХ-д олгосон
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	90.0	0.0	-	90.0
2	Үнэмлэх хэвлүүлэх зардал	2,680.0	0.5	-	2,680.0
3	Сургалтын зардал	18,976.0	3.5	-	18,976.0
4	Бичиг хэргийн зардал	13,250.0	2.5	11,250.0	2,000.0
5	Шуудан холбооны зардал	13,450.0	2.5	13,350.0	100.0
6	Унааны зардал	55,175.0	10.3	47,532.0	7,643.0
7	Санал авах байр бэлтгэх зардал	23,100.0	4.3	15,750.0	7,350.0
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	23,610.0	4.4	14,510.9	9,099.1
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	650.0	0.1	-	650.0
10	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	3,675.0	0.7	3,640.0	35.0
11	Сурталчилгааны зардал	8,000.0	1.5	-	8,000.0
12	Томилолтын зардал	8,214.0	1.5	-	8,214.0
13	Болзошгүй зардал	7,810.0	1.5	-	7,810.0
14	Урамшуулал, хоолны зардал	308,820.0	58.0	303,300.0	5,520.0
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	43,100.0	8.1	-	43,100.0
16	Мэдээ дамжуулах унааны зардал	4,235.0	0.8	2,450.8	1,784.2
НИЙТ ДҮН		534,835.0	100.0	411,783.7	123,051.3
Эзлэх хувь				77.0	23.0



Хүснэгтээс харахад нийт зардлын 77 хувь буюу **411,783.7** мянган төгрөгийг сумын сонгуулийн хороонд, **23** хувь буюу **123,051.3** мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагаанд зарцуулахаар тус тус хуваарилсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1 ээс үзнэ үү/

Улсын төсвөөс хуваарилсан нийт төсвийн дүнд зардлын эдийн засгийн ангиллаар эзлэх хувь хэмжээг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График №1



Графикаас харахад нийт зардлын 66.0 хувийг сонгуулийн хороонд ажилласан гишүүд болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал хоолны зардал, 10 хувийг унааны зардал буюу шатахууны зардал эзэлж байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн зөвлөмж, аргачлалын дагуу 19 сумдын 101 хэсгийн хороонд төсвийг хуваарилахдаа нутаг дэвсгэрийн хэмжээ сонгогчийн тоо болон сумын сонгуулийн хороо, санал авах байр тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан дараах байдлаар хуваарилсан байна.



Хүснэгт-2 /мян.төг/

№	Сумдын нэрс	Хуваарилсан санхүүжилт		Үлдэгдэл
		Төсөв	Гүйцэтгэл	
1	Ихтамир	24,305.8	24,305.8	-
2	Чулуут	20,273.7	20,273.7	-
3	Хангай	22,406.1	22,406.1	-
4	Тариат	26,121.5	26,121.5	-
5	Өндөр-улаан	21,999.0	21,873.0	126.0
6	Эрдэнэмандал	24,904.2	24,904.2	-
7	Жаргалант	21,815.4	21,815.4	-
8	Цэцэрлэг	20,098.2	20,098.2	-
9	Хайрхан	19,125.8	19,125.8	-
10	Батцэнгэл	22,925.3	22,571.1	354.2
11	Өлзийт	16,282.4	16,282.4	-
12	Өгийнуур	18,543.6	18,543.6	-
13	Хашаат	18,732.8	18,732.8	-
14	Хотонт	22,048.1	22,048.1	-
15	Цэнхэр	24,780.5	24,780.5	-
16	Төвшрүүлэх	15,201.3	15,151.3	50.0
17	Булган	15,992.0	15,992.0	-
18	Цахир	15,781.0	15,781.0	-
19	Эрдэнэбулган	40,447.0	40,447.0	-
НИЙТ ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ		411,783.7	411,253.5	530.2

Дээрх хүснэгтээс харахад сумдад 411,783.7 мянган төгрөгийн санхүүжилтийг Аймгийн сонгуулийн хорооноос олгосноос гүйцэтгэлээр 411,253.5 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд Батцэнгэл, Төвшрүүлэх, Өндөр-Улаан сумдын сонгуулийн хороодоос нийт 530.2 мянган төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг буцаан төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 2 АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА

2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

Улсын төсвөөс олгосон хөрөнгийг аймаг, сумдын сонгуулийн хороодод хуваарилахдаа Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ийн сонгуулийн тухай хуулийн 10.1, болон СЕХ-ны чиглэл, удирдамжийн дагуу зардлыг эдийн засгийн 16 ангиллаар хуваарилсан ба гүйцэтгэл нь дараах байдалтай байна.



Зардлын ангиллаар харуулбал:

Хүснэгт №3 /мян.төг/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл буюу хэмнэлт
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	90.00	82.60	7.40
2	Үнэмлэх хэвлүүлэх зардал	2,680.00	2,675.75	4.25
3	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	30,226.00	30,225.70	0.30
4	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	15,350.00	15,350.00	-
5	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны шуудан холбооны зардал	47,632.00	47,250.48	381.53
6	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны унааны зардал	23,393.00	19,973.00	3,420.00
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	21,860.90	21,810.90	50.00
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	9,099.10	8,982.00	117.10
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	4,290.00	4,290.00	-
10	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	35.00	0.00	35.00
11	Сурталчилгааны зардал	8,000.00	8,000.00	-
12	Томилолтын зардал	8,214.00	5,264.50	2,949.50
13	Болзошгүй зардал	7,810.00	6,473.80	1,336.20
14	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	308,820.00	308,670.00	150.00
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	43,100.00	43,100.00	-
16	Мэдээ дамжуулах унааны зардал	4,235.00	4,024.80	210.20
НИЙТ ДҮН		534,835.00	526,173.53	8,661.48

Нийт олгосон санхүүжилтээс 526,173.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 8,661.4 мянган төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн бөгөөд сонгуулийн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны тухайд зардлын төсөв, гүйцэтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт №4 /мян.төг/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	90.00	82.60	7.40
2	Үнэмлэх хэвлүүлэх зардал	2,680.00	2,675.75	4.25
3	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	18,976.00	18,975.70	0.30
4	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	2,000.00	2,000.00	-



5	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны шуудан холбооны зардал	100.00	72.67	27.33
6	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны унааны зардал	7,643.00	4,223.00	3,420.00
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	7,350.00	7,350.00	-
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	9,099.10	8,982.00	117.10
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	650.00	650.00	-
10	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	35.00		35.00
11	Сурталчилгааны зардал	8,000.00	8,000.00	-
12	Томилолтын зардал	8,214.00	5,264.50	2,949.50
13	Болзошгүй зардал	7,810.00	6,473.80	1,336.20
14	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	5,520.00	5,370.00	150.00
15	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	43,100.00	43,100.00	-
16	Мэдээ дамжуулах унааны зардал	1,784.20	1,700.00	84.20
НИЙТ ДҮН		123,051.30	114,920.02	8,131.28

Дээрх хүснэгтээс харахад аймгийн сонгуулийн хороо нийт зардлаас унааны зардлыг 3,420.0 мянган, томилолтын зардлыг 2,949.5 мянган, болзошгүй зардлыг 1,336.2 мянган, бусад 8 төрлийн зардлыг 425.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, сонгуулийн зардлыг нийт 8,131.2 мянган төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан байна.

Сонгуулийн зардлын зарцуулалттай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Хангай сумын Сонгуулийн хороо 210.0 мянган төгрөгөөр хэсгийн хороодод мотор түрээслэн ажилласан боловч түрээсийн гэрээг байгуулаагүй,
- Батцэнгэл сумын Сонгуулийн хороо 350.0 мянган төгрөгийн томилолтын зардалд анхан шатны баримтыг дутуу бөглөсөн.
- Жаргалант сумын Сонгуулийн хороо унааны зардлыг СЕХ-оос ирүүлсэн аргачлал, удирдамжийн дагуу 1км-ийг 500 төгрөгөөр тооцож олгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5 дахь заалт болон СЕХ-ны СЕХ-ны 2020.10.07-ны 3/465 дахь заалтыг зөрчсөн байна.

Мөн Жаргалант сумын 51-р хэсгийн хороо, Эрдэнэбулган сумын 7-р багт нэмэлт сонгууль явагдаж нийт 1,607.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Зарцуулалтыг дэлгэрэнгүй авч үзвэл:

Хүснэгт №5 /мян.төг/

№	Зардлын нэр	Жаргалант сумын 51-р хэсгийн хороо	Эрдэнэбулган сумын 7-р баг	НИЙТ ДҮН
1	Унааны зардал	857.0	-	857.0
2	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	200.0	-	200.0
3	Хоолны зардал	180.0	370.0	550.0
НИЙТ ДҮН		1,237.0	370.0	1,607.0



Эрдэнэбулган суманд явагдсан нэмэлт сонгуулийн зардалд зарцуулсан хоолны зардлыг аймгийн сонгуулийн хорооноос тухайн иргэдийн данс руу шууд шилжүүлсэн. Харин Жаргалант сумын сонгуулийн хороонд 1,237.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Мөн СЕХ-оос ирүүлсэн удирдамжид зааснаар шатахууны тооцооллыг 1км-ийг 500-550 төгрөгөөр тооцож ажиллах зөвлөмж хүргүүлсний дагуу Сонгуулийн хороонд сонгууль зохион байгуулахтай холбоотой олгосон унаа, шатахууны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тулган шалгахад дараах байдалтай байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6 /мян.төг/

Төсвийн хуваарь	Унааны зардал		(ICP) машиныг аймгийн СХ-ноос хүлээн авах, өгөх зардал	ХХ-ны даамал (ICP) машиныг сумын СХ-нд хүлээлгэн өгөх зардал	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх		Мэдээ дамжуулах унааны зардал	НИЙТ ДҮН
	Аймаг, сумын СХ-оор	Хэсгийн хороо			Аймаг, сумын СХ	Хэсгийн хороо		
Төлөвлөгөө	13,818.0	41,357.0	19,719.3	3,890.7	35.0	3,640.0	4,235.0	86,695.0
Гүйцэтгэл	10,398.0	41,002.8	19,552.2	3,890.7	-	3,640.0	4,024.8	82,508.5
Зөрүү	3,420.0	354.2	167.1	-	35.0	-	210.2	4,186.5

Хүснэгтээс харахад сонгуулийн хороодод нийт 86,695.0 мянган төгрөгийн унаа шатахууны зардлыг олгосон боловч гүйцэтгэлээр 82,508.5 мянган төгрөгийг зарцуулж 4,186.5 мянган төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлсэн нь нийт төвлөрүүлсэн санхүүжилтийн 48.3 хувийг эзэлж байна.

Аудитаар унаа, шатахууны зарцуулалтыг анхан шатны баримтаар сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодоор түүвэрлэн шалгахад Жаргалант сумын сонгуулийн хороо нь СЕХ-ны 2020.10.07-ны 3/465 тоот албан бичигт заасны дагуу 1км-ийг 500 төгрөгөөр тооцож шатахууны зарцуулалтын тайланг гаргаагүй байна.

2.2. Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг бодитоор тайлагнаж аудитаас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Орон нутгийн сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланг аудитын дүнтэй харьцуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №7

Зардлын нэр	Аймгийн Сонгуулийн хороонд улсын төсвөөс олгосон нийт зардлын дүн			Сумын Сонгуулийн хороо			Аймгийн Сонгуулийн хороо		
	Аймгийн СХ-ны тайлангаар гүйцэтгэл	Аудитаар зардлын гүйцэтгэл	Зөрүү буюу гүйлгэн зарцуулсан	Тайлангаар зардлын дүн	Аудитаар зардлын дүн	Зөрүү буюу гүйлгэн зарцуулсан	Тайлангаар зардлын дүн	Аудитаар зардлын дүн	Зөрүү буюу гүйлгэн зарцуулсан
Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	82.6	82.6	0.0	0.0	0.0	0.0	82.6	82.6	0.0



Үнэмлэх хэвлүүлэх зардал	2675.8	2675.8	0.0	0.0	0.0	0.0	2675.8	2675.8	0.0
Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	18975.7	18975.7	0.0	0.0	0.0	0.0	18975.7	18975.7	0.0
Бичиг хэргийн зардал	13250.0	13283.0	33.0	11250.0	11283.0	33.0	2000.0	2000.0	0.0
Шуудан холбооны зардал	13422.7	13422.7	0.0	13350.0	13350.0	0.0	72.7	72.7	0.0
Унааны зардал	51400.8	51400.8	0.0	47177.8	47177.8	0.0	4223.0	4223.0	0.0
Санал авах байр, төрийн далбаа бэлтгэх зардал	23100.0	23067.0	(33.0)	15750.0	15717.0	(33.0)	7350.0	7350.0	0.0
Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах хүлээлгэн өгөх зардал	23442.9	23442.9	0.0	14460.9	14460.9	0.0	8982.0	8982.0	0.0
МТБ-ийн мэдээ дамжуулах, холбоо, унааны зардал	650.0	650.0	0.0	0.0	0.0	0.0	650.0	650.0	0.0
Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3640.0	3640.0	0.0	3640.0	3640.0	0.0	0.0	0.0	0.0
Сурталчилгааны зардал	8000.0	8000.0	0.0	0.0	0.0	0.0	8000.0	8000.0	0.0
Томилолтын зардал	5264.5	5264.5	0.0	0.0	0.0	0.0	5264.5	5264.5	0.0
Болзошгүй зардал	6473.8	6473.8	0.0	0.0	0.0	0.0	6473.8	6473.8	0.0
Гишүүний урамшуулал, хоолны зардал	308670.0	308670.0	0.0	303300.0	303300.0	0.0	5370.0	5370.0	0.0
МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	43100.0	43100.0	0.0	0.0	0.0	0.0	43100.0	43100.0	0.0
Мэдээлэл дамжуулах унааны зардал	4024.8	4024.8	0.0	2324.8	2324.8	0.0	1700.0	1700.0	0.0
Нийт дүн	526173.5	526173.5	0.0	411253.5	411253.5	0.0	114920.0	114920.0	0.0

Дээрх хүснэгтээс харвал Эрдэнэбулган сумын сонгуулийн хороо нь 33.0 мянган төгрөгийн санал авах байр тохижуулах зардлыг бичиг хэргийн зардал руу шилжүүлэн зарцуулсныг тайланд тусгаагүй, хуваарилсан зардлын дүнгээр тайланг бэлтгэсэн зөрчлийг эс тооцвол аймаг, сумын сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг бодит гүйцэтгэлээр тайлагнасан байна.

Өөрөөр хэлбэл УИХ-ын сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаас эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, холбогдох журмыг мөрдөж ажиллах тухай өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

2.3. Хөрөнгийн зарцуулалтанд тавих дотоод хяналт үр дүнтэй байна.

СЕХ-ний 2016 оны 03 сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоолын 4.4 “Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, батлагдсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна” гэж заасны дагуу Архангай аймгийн сонгуулийн хороо болон сонгуулийн хэсгийн хороодын дарга нарыг 2020 оны 07 сарын 30-ны өдрийн 35 тоот Аймгийн ИТХТ-ийн болон аймгийн сонгуулийн хорооны даргын тогтоолоор томилж хяналт тавьж, зарцуулах эрхийг нээж өгчээ. Салбар хороодын дарга, нарийн бичгийн дарга нар олгосон санхүүжилт бүрийг хяналттай, зориулалтын дагуу зарцуулж санхүүжилтийн тайланг архивын нэгж болгон аймгийн архивт хүлээлгэн өгсөн байна.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс орон нутагт олгосон зардлын төлөвлөлт, зарцуулалт,



гүйцэтгэлд дүгнэлт гаргах аудитаар 4 заалт бүхийн зөвлөмж хүргүүлсэн бөгөөд биелэлтийг 2020 оны 11 сарын 05-ны өдрийн 64 тоот аймгийн сонгуулийн хорооны даргын албан бичгээр ирүүлсэн бөгөөд энэ удаагийн аудитаар хэрэгжилтийг тулган шалгахад дараах байдалтай байлаа. Үүнд:

1. Сумдын сонгуулийн хороонд мэргэжлийн нягтлан бодогчийг томилон ажиллуулсан. /Хавсралт судалгаа №3/
2. Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан СХ-ны дарга, нягтлан бодогч нарт мэргэжил аргазүйн зөвөлгөө өгч зардал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх үүрэг чиглэл хүргүүлсэн.
3. Шатахууны зарцуулалттай холбогдон гарсан анхан шатны баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй зөрчил давтан гараагүй.
4. Сонгууль зохион байгуулахтай холбогдон гарсан зардлыг зардал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх зөрчил энэ удаагийн аудитаар илрээгүй, сумын СХ-д албан бичгээр зардал хооронд гүйлгэн зарцуулаагүй тайлбарыг тайлангийн хамт ирүүлсэн байна.

Архангай аймаг, сумын ИТХ-ийн 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сайжирч, өмнөх аудитаас хүргүүлсэн зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

----- ооОоо -----



АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн зорилт бүрд дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
2. Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна

Ерөнхий дүгнэлт: **ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛЖ, АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР